



## ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

Коронавируст халдварын цар тахлыг дэлхий нийтээрээ даван туулж буй энэ цаг үед Монгол Улс ч мөн хүнд сорилттой өдөр тутам тулгарч байна. Энэ цаг үед үүсээд буй нөхцөл байдалд хөндлөнгийн байр сууринаас дүн шинжилгээ хийж, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулахад хувь нэмэр болох гарц шийдэл санал болгох ажлыг эхлүүлээд байгаа билээ. Энэ

удаагийн дугаарт цар тахлын дэгдэлтийг зогсооход технологи ашигласан зарим орны туршлагаас танилцуулж байна. Энэхүү туршлагыг шууд нэвтрүүлэх гэхээс илүүтэй технологи ашиглахдаа хүний эрхийг хамгийн бага хязгаарлах, эрх мэдлийг урвуулан ашиглахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн оновчтой шийдлийг олоход хувь нэмэр оруулна хэмээн найдаж байна.

### НЭГ. ОРШИЛ

Ковид-19 цар тахлын эсрэг ихэнх Засгийн газрууд хөл хорио тогтоох аргыг нийтлэгээр ашиглажээ. Гэвч, зорчих эрхийг хязгаарласан нь эдийн засгийг царцааж, иргэдийн орлого олох боломжийг хаахад хүргэсэн нь урт хугацаандаа цар тахлаас ч илүү хор хөнөөлтэй тул улс орнууд хатуу хөл хорионы дэглэмийг удаан хугацаагаар хэрэгжүүлэхээс аль болох зайлсхийж эхлээд байна. Үүний оронд нийгмийн амьдралд оролцоходоо хүн хоорондын зай барих, гараа тогтмол ариутгах, амны хаалт зүүх зэргээр халдвар хамгааллын дэглэм сахихыг иргэддээ уриалах болсон. Гэсэн хэдий ч энэ нь цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд төдийлөн үр дүнтэй байж чадахгүй байгааг өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй цар тахлын тохиолдлын тоо харуулж байна.

Тиймээс цар тахлын тархалтыг хумьж чадсан хэмээн үнэлэгдэж буй БНХАУ, Вьетнам, Тайвань улсын туршлагыг судалж, харьцуулалт хийлээ. Эдгээр улсын бусдаас ялгаатай бөгөөд өөр хоорондоо нийтлэг хэрэгжүүлсэн арга хэмжээ бол гар утасны аппликэйшнээр дамжуулан мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, “Ковид-19”-ийн эерэг тохиолдол илэрсэн үед тухайн этгээдийн өмнөх

өдрүүдэд очсон газар, ойрын хавьтлыг түргэн шуурхай илрүүлж, цар тахлыг цааш тархахаас шуурхай сэргийлж чадсан явдал юм. Өөрөөр хэлбэл, технологийн тусламжтайгаар цар тахлын эсрэг хариу арга хэмжээ хэрэгжүүлсэн гэсэн үг.

Гэхдээ энэ арга хэмжээг иргэд, судлаачдын зүгээс төр нь иргэдээ мөрдөн мөшгөж, халдашгүй байдал, хувийн орон зайд нь бүдүүлгээр халдаж байгаа хэрэг хэмээн шүүмжилж байна. Үүний эсрэг хариу арга хэмжээ бол хатуу хөл хорио бөгөөд энэ нь ч мөн олон сөрөг үр дагавартай. Тиймээс иргэд хатуу хөл хорионд гэрээс гарахгүй байх уу, эсвэл зорчсон газрынхаа мэдээллийг мэдээллийн санд өгөх үү хэмээх сонголтын өмнө тулаад байна.

Магадгүй “Ковид-19” цар тахлын эсрэг вакцин гарч цаашид хүний эрхийг хязгаарлах шаардлагагүй үе ирж болох ч өөр бусад шинэ төрлийн халдварт өвчний улмаас дахин ийм сорилттой тулгарч болзошгүй билээ. Тиймээс хатуу хөл хорио тогтоохын эсрэг шийдэл болох зорчих хөдөлгөөний мэдээллийг технологийн тусламжтай бүртгэх аргыг сайтар судлах шаардлага бидний өмнө тулгамдаж байна.

Тухайлбал, дотоодын анхны тохиолдол болох жолооч Д-ийн шинжилгээний хариу 11 дүгээр сарын 10-ны өдөр эерэг гарсан ч түүний зорчсон газрын мэдээлэл 11 дүгээр сарын 14-ний өдөр л ил тод болсон. Өөрөөр хэлбэл, Д-ийн ойрын хавьтал хийгээд, зорчсон газрыг бүрэн тодорхойлоход багадаа 3 өдрийг зарцуулжээ.<sup>1</sup> Энэ хугацаа уртсах тусам цар тахал дэгдэх өндөр эрсдэлтэй.

Түүнчлэн иргэд хаагуур явсан, хэнтэй уулзсанаа нарийвчлан санахгүй байх тохиолдол ч элбэг. Тиймээс иргэдийн зорчсон мэдээллийг хадгалдаг аппликэйшн байх нь ач холбогдолтой хэдий ч уг мэдээллийг нийтийн эрүүл мэндийн бус зорилгоор ашиглах өндөр эрсдэл ч үүнийг дагалддагийг мартаж болохгүй.

## ХОЁР. ЦАР ТАХАЛТАЙ ТЭМЦЭХДЭЭ ТЕХНОЛОГИ АШИГЛАЖ БУЙ ОРНУУДЫН ТУРШЛАГА



### 2.1. БНСВУ-ын хэрэгжүүлсэн бодлого, туршлага

Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс (БНСВУ) нь БНХАУ-тай залгаа, зүүн өмнөд азид оршдог улс бөгөөд ойролцоогоор 97 сая хүн амтай. Тус улсад “Ковид-19” цар тахлын бүртгэгдсэн нийт тохиолдол одоогийн байдлаар (2020 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр) 1321, түүнээс 1153 нь бүрэн эдгэрсэн, харин идэвхтэй тохиолдол ердөө 133 байгаа нь Ковид-19 цар тахлын эсрэг БНСВУ-ын авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, бодлогыг судлах ач холбогдолтойг харуулж байна.

БНСВУ-д “Ковид-19”-ийн анхны эерэг тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 23-нд илэрч Засгийн газар нь шуурхай арга хэмжээ авч эхэлжээ. Тухайлбал, олон улсын нислэгийг зогсоож, хөл хорио тогтоон, олон нийтийн сүлжээгээр сэрэмжлүүлэг мэдээлэл явуулсан бөгөөд энэхүү бодлого, үйл ажиллагаагаа технологитой уялдуулж чадсанаараа онцлогтой. Тодруулбал, гар утасны “Bluezone” гэх аппликэйшн гаргаж, иргэдийн хэрэглээнд оруулснаар “Ковид-19”-ийн эерэг тохиолдлыг илрүүлэхэд маш том түлхэц үзүүлж чаджээ.

Тус аппликэйшний тусламжтайгаар “Ковид-19”-ээр өвчилсөн хүний явсан зам, газар, ойртсон хүмүүс зэргийг мэдэх боломжтой болсон байна. Түүнчлэн тус аппликэйшнийг утсандаа суулгасан хүн, “Ковид-19”-ээр өвчилсөн хүний явсан газар болон түүний ойролцоо очиход сэрэмжлүүлэг өгөх тохиргоотой. Үүний үр дүнд тархалтыг шуурхай таслан зогсоох боломжтой болжээ. Уг аппликэйшн 2020 оны 8 дугаар сарын 20-ны

байдлаар 20 гаруй сая татагджээ. Ийнхүү БНСВУ эдийн засгаа эрсдэлд оруулалгүй цар тахлын тархалтыг хяналтдаа оруулж чадсан байна.

Мөн “Ковид-19”-ийн шинжилгээ эерэг гарсан тохиолдолд тухайн өвчтөний ойрын хавьтлыг нэн түрүүнд тодорхойлж, ингэхдээ хавьтлын зэргийг 4 ангилан, тус ангилалд багтсан бүх хүнийг шинжилгээнд хамруулжээ. Судалгаанаас үзэхэд эерэг тохиолдлын 78.8 хувь эхний хавьтлаас халдварласан байна. Хоёр болон гуравдугаар зэргийн хавьтлаас халдварласан тохиолдол илэрхий бага байсан ч дөрөвдүгээр зэргийн хавьтал хүртэлх хүмүүсээс шинжилгээ авсан байна.

Дашрамд хэлэхэд, хөл хориог 3 түвшинд ангилжээ. Нэгдүгээр түвшин нь гэрийн хөл хорио, хоёрдугаар түвшин нь гадаадаас ирсэн иргэдийг эмнэлгийн бус байгууламжид 14 хоногийн тусгаарлалт, гуравдах түвшин нь “Ковид-19”-ээр халдварласан хүнийг эмнэлгийн тусгаарлалтад оруулах юм. Гэрийн хөл хорионоос бусад түвшний тусгаарлалтын зардлыг иргэншил хамааралгүй төр хариуцжээ.

Тус улсын “Ковид-19” цар тахлын эсрэг явуулсан арга хэмжээг Дэлхийн банк ихэд сайшаасан бөгөөд 2020 онд эдийн засаг нь хурдацтай өсөж буй орнуудын тэргүүн эгнээнд бичигдэж байна.

### 1.2. Тайвань Улсын хэрэгжүүлсэн бодлого, туршлага

Тайвань нь 26.5 сая хүн амтай Зүүн азид орших БНХАУ, Филиппин, Япон улсуудтай далайн зурвасаар хиллэдэг арлын улс юм. Тус улсад

<sup>1</sup> <https://news.mn/r/2372755/>; <http://www.zалууcom.mn/read/5349g56b4>; <https://zarig.mn/ng0>; <http://www.zms.mn/a/81578>; [https://updown.mn/135041.html?fbclid=IwAR3iJ9LomyjgexqxrG7rvQHaciEWOzbx\\_ThkKrC3mpjCXwl7IZ2NRARXMuw](https://updown.mn/135041.html?fbclid=IwAR3iJ9LomyjgexqxrG7rvQHaciEWOzbx_ThkKrC3mpjCXwl7IZ2NRARXMuw)

Ковид-19 цар тахлын анхны тохиолдол 2020 оны 1 дүгээр сарын 21-ний өдөр бүртгэгдсэн боловч Засгийн газраас шуурхай үр дүнтэй арга хэмжээ авсны үр дүнд өнөөдрийн байдлаар (2020 оны 11 дүгээр сарын 27) “Ковид-19”-өөр өвчилсөн 77 өвчтөн хэвтэн эмчлүүлж байна. Тайваньд “Ковид-19”-ийн тохиолдол нийт 639 бүртгэгдсэнээс 555 нь эдгэрч, 7 хүн нас барсан бөгөөд өндөр хөгжилтэй орнууд дундаас хамгийн бага “Ковид-19”-ийн тохиолдол бүртгэгдсэн улсад зүй ёсоор тооцогдож байна.<sup>2</sup>

Тайвань Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн бодлогыг дараах 3 байдлаар багцаллаа. Нэгдүгээрт, амны хаалтыг богино хугацаанд их хэмжээгээр үйлдвэрлэж цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайн авсан. Амны хаалтын бодлогод 2003 онд гарсан SARS-ийн эсрэг хэрэгжүүлсэн туршлага ихэд нөлөөлсөн талаар дурджээ. Хоёрдугаарт, *Big data* буюу иргэдийн мэдээллийн санд суурилсан дижитал технологийг тахлын тархалтыг зогсооход ашигласан байна. Гуравдугаарт, төр болон иргэний нийгмийн далайцтай хамтын ажиллагаа, үйл ажиллагааны нээлттэй ил тод байдал, мэдээлэл харилцааны бодлого хэмээн үзжээ.<sup>3</sup>

Эдгээрээс нэг болон гуравдугаар бодлого нь манай улсад тодорхой хэмжээнд хэрэгжиж байгаа тул дэлгэрүүлэн авч үзэлгүй орхиж, харин цаашид хэрэгжүүлэхээр яригдаж байгааг харгалзан хоёрдугаар бодлогыг тодрууллаа.

Тайвань Улсын Засгийн газар “Ковид-19” халдварын цар тахлын шинэ тохиолдол болон халдвар авсан хүмүүсийн ойрын хавьтлуудыг тогтоох, гадаадаас ирсэн иргэдээ хянах үүднээс тухайн иргэдийн хаашаа зорчсон мэдээллийг *Big data* буюу “мэдээллийн нэгдсэн сан”-г ашиглаж байна. Үүний дүнд өвчтөнүүд явсан газар, уулзсан хүмүүсээ мэдээлэхгүй байх, мартаж зэргээр халдварын ойрын хавьтлыг илрүүлэхэд

хугацаа алдахаас сэргийлж чаджээ. Тухайлбал, “Ковид-19”-ээр өвчилсөн хүний хаагуур зорчсон мэдээллийг эхлээд 14 хоногоор авч байсан бол дараа нь 30 хоногоор авах болжээ. Хаагуур зорчсон талаарх мэдээллийг тухайн этгээдийн хэрэглэдэг утасны үйлчилгээ үзүүлэгч үүрэн харилцааны компаниудаас гаргуулан авчээ. Түүнчлэн энэхүү аргыг гэрээр тусгаарлагдсан хүмүүс дээр ч мөн ашиглажээ.<sup>4</sup>

Халдвар авсан хүний зорчсон газарт байгаа хүмүүсийг гэрийн тусгаарлалтад байх шаардлага тавьж, тухайн байгаа газраасаа гарсан тохиолдолд тэдгээр иргэдэд анхааруулга бүхий мессеж очихын зэрэгцээ, тухайн нутаг дэвсгэрийн цагдаа, холбогдох албан тушаалтанд энэ тухай мэдээлэл очих байдлаар програмчилжээ.<sup>5, 6</sup> Мөн гадаадаас ирсэн иргэдээ гэрийн тусгаарлалтад 14 хоног байх шаардлага тавьж, гэртээ байгаа эсэхийг гар утасны GPS-ийн тусламжтайгаар мэдэх бөгөөд тухайн этгээд утсаа өөртөө ойр байлгаж буй эсэхийг өдөрт хоёр удаа залгаж шалгадаг байна. Гэрийн тусгаарлалтын хориог зөрчвөл 3-33 мянган долларын торгууль ногдуулахаар зохицуулалт хийжээ. Тусгаарлалтын сүүлийн өдрөө гэрээсээ дур мэдэн гарсан этгээдийг 33 мянган доллароор торгосон тохиолдол ч гарчээ.<sup>7</sup>

### 1.3. БНХАУ-ын хэрэгжүүлсэн бодлого, туршлага

БНХАУ-ын Хүбэй мужийн шинэ коронавирусийн уушгины тахлаас урьдчилан сэргийлж, хянах төв 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр мэдэгдэл гаргажээ. Тус мэдэгдэлд 2020 оны 3 дугаар сарын 25-ны 00:00 цагаас эхлэн Хүбэй мужийн Үхань хотоос бусад орон нутгийн хүмүүсийн Хүбэйгээс гарах хөл хориог цуцалж, тэднийг Хүбэйн Эрүүл мэндийн код дээр суурилсан «Ногоон код» авсан нөхцөлд аюулгүй, дэг журамтай зорчиж болох зохицуулалт хийсэн байна.<sup>8</sup> Үхань хотоос гарахгүй хатуу хөл хориог 2020 оны 4 дүгээр сарын 8-ны 00:00 цагаас эхлэн цуцалсан. Харин “Ногоон код”

<sup>2</sup> <https://www.worldometers.info/coronavirus/country/taiwan/>

<sup>3</sup> Wei-Ting Yen “Taiwan’s COVID-19 Management: Developmental State, Digital Governance, and State-Society Synergy” <https://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/aspp.12541>

<sup>4</sup> <https://www.ncbi.nlm.nih.gov/pmc/articles/PMC7323533/>

<sup>5</sup> Wei-Ting Yen “Taiwan’s COVID-19 Management: Developmental State, Digital Governance, and State-Society Synergy” <https://onlinelibrary.wiley.com/doi/10.1111/aspp.12541>

<sup>6</sup> <https://www.jmir.org/2020/5/e19540/>

<sup>7</sup> <https://www.mei.edu/publications/taiwans-model-combating-covid-19-small-island-big-data>

<sup>8</sup> [http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c\\_1125763807.htm](http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c_1125763807.htm)

авсан нөхцөлд хотоос аюулгүй, эмх цэгцтэй зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.<sup>9</sup>

БНХАУ-ын томоохон технологийн компани болох *Alibaba Group Holding Ltd* болон *Tencent Holdings Ltd* компаниудтай хамтран Ханжоу хотод анх удаа халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх, хянах зорилгоор иргэдийн хөдөлгөөнийг хянах, болзошгүй эрсдэлийг бууруулахад *Big data* болон QR код зэрэг технологи ашигласан системийг нэвтрүүлсэн байна. Үүнийг *one map, one QR code, and one index* хэмээн нэрлэжээ.

Ухаалаг утсанд аппликэйшн суулгах замаар энэхүү тандалт, хяналтын систем ажилладаг байна. Тус аппликэйшнийг ашиглахын тулд тухайн иргэн өөрийн нэр, регистр, хаяг, гар утасны дугаар зэрэг хувийн мэдээллээ бүрэн бөглөх үүрэгтэй бөгөөд үүний дараа явсан газрын маршрут, уулзсан хүмүүсийн талаарх мэдээллийг оруулах, мөн өөрт илэрч буй биеийн шинж тэмдгийг тодорхойлсон хэсгийг бөглөх ёстой ажээ. БНХАУ-ын хувьд иргэдийг цаг тутамд өөрийн халууныг хэмжиж, мэдээлэхийг үүрэг болгосон бөгөөд энэхүү мэдээллийг бөглөж, баталгаажуулсны дараа эрх бүхий байгууллага ногоон, шар, улаан QR кодын алийг олгохыг шийддэг байна.

Тус эрүүл мэндийн QR кодын өнгөөс шалтгаалж зорчих эрхийн хязгаарлалтын хугацаа зохицуулагддаг. Ногоон эрүүл мэндийн QR код нь зөвшөөрөгдсөн буюу чөлөөтэй зорчих боломжтой, шар эрүүл мэндийн QR код нь анхаарах буюу долоо хоногийн хугацаанд өөрийгөө тусгаарлах (*self-quarantine*), улаан эрүүл мэндийн QR код нь аюултай буюу 14 хоногийн хугацаанд өөрийгөө бусдаас тусгаарлахыг илтгэдэг байна.<sup>10</sup> Одоо БНХАУ-ын олон хот энэхүү тандалт, хяналтын системийг хэрэглэх болсон бөгөөд зорчих хөдөлгөөн хийж буй иргэдийн мэдээллийг хяналтдаа авсан байна.

Эрүүл мэндийн QR код бүхий энэхүү апплекэйшн анх гарах үед олон зөрчил бүртгэгджээ. Тухайлбал, буруу код олгосны улмаас зорчих эрх нь хязгаарлагдсан тухай гомдол иргэдээс их ирсэн байна. Үүнийг шийдэх зорилгоор цахим өргөдөл хүлээн авах цэс нэмж, гаргасан шийдвэрээ эргэж хянах, хурдан, шуурхай хариу өгөх нөхцөлийг бүрдүүлжээ.<sup>11</sup> БНХАУ-ын хувьд эрүүл мэндийн QR системийг нэвтрүүлэхдээ өөрийн улсын томоохон компаниудыг татан оролцуулж, үйл ажиллагаанд нь тогтвортой, нэгдсэн байдлаар хяналт тавьж ажилласан байна.

#### 1.4. Цар тахалтай тэмцэхэд технологи ашиглах бол анхаарах зүйл

Технологийг цар тахалтай тэмцэхдээ ашиглах бол Эмнести интернэшнл болон 140 гаруй иргэний нийгмийн байгууллага хамтран гаргасан “Ковид-19 цар тахалтай холбогдуулан дижитал хяналт шалгалт хийх үед анхаарах зөвлөмж”<sup>12</sup>-ийг нухацтай авч үзэх хэрэгтэй. Тус зөвлөмжид Засгийн газрын авч буй арга хэмжээ ил тод, нээлттэй байх, технологи ашиглан хяналт, ажиглалт хийхдээ хэдий хугацаанд үргэлжлэхийг тодорхойлсон байх, тус хугацаанд зорилгодоо хүрсэн бол цуцлах, хувь хүний нууцад халдахгүй байх, Засгийн газар хувь хүний мэдээллийг цуглуулах, дамжуулах, боловсруулах, хадгалахтай холбогдсон аливаа төхөөрөмж, програм хангамж, үйлчилгээний аюулгүй байдлыг хангахын тулд бүхий л шаардагдах арга хэмжээг авах зэргийг анхааруулсан байна.<sup>13</sup>

Тиймээс технологи ашиглаж, цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах бол зорилгодоо нийцсэн бөгөөд тохирсон байх, хэн нэгэнтэй хүнлэг бус, хэрцгий хандахгүй байх, халдашгүй эрхийг нь хүндэтгэх, хувь хүний нууцыг хадгалах, зөвхөн цар тахлын хүрээнд ашиглах, бусад нөхцөлд цуцлах, иргэдэд технологийн талаарх мэдээллийг ил тод, нээлттэй, хүртээмжтэй өгөхөд анхаарч ажиллах шаардлагатай.

<sup>9</sup> [http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c\\_1125763807.htm](http://mn.news.cn/mn/gnxw/2020-03/25/c_1125763807.htm)

<sup>10</sup> <https://www.weforum.org/agenda/2020/03/coronavirus-covid-19-hangzhou-zhejiang-government-response/>

<sup>11</sup> <https://edition.cnn.com/2020/04/15/asia/china-coronavirus-qr-code-intl-hnk/index.html>

<sup>12</sup> <https://amnesty.mn/index.php/2019-06-05-14-51-12/545-2020-05-20?fbclid=IwAR1o33dKH7Ha7cOPb3TDZVCca6IaOuTp0wE8el1IGwE02Q3Wm5uV3rQkgkY>

<sup>13</sup> <https://amnesty.mn/>

Түүнчлэн дээрхи технологийг ашиглаж Ковид-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахдаа тус харилцааг зохицуулсан журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн гаргах шаардлагатай.

Ийнхүү журмыг гаргаснаар иргэд хөдөлгөөнд оролцохдоо заавал QR код уншуулах, утсандаа апп татаж суулгах үүрэг хүлээх эрх зүйн үндэс бүрдэнэ.

## ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ



Урт хугацааны хатуу хөл хорио нь хэт өндөр зардалтай тул технологийн дэвшлийг ашиглах замаар цар тахлын дэгдэлтээс сэргийлэх чиглэлээр дараах саналыг гаргаж байна.

- Зорчсон мэдээллийг хадгалдаг аппликэйшн бий болгох, гэхдээ “Ковид-19” цар тахлын тархалтыг зогсоох зорилгоор зөвхөн “Ковид-19” цар тахлын эерэг тохиолдол, тухайн тохиолдлын хавьтлуудын зорчсон мэдээлэлд нэвтрэх эрхийг олгох, мөн тус мэдээллийг өөр зорилгоор ашиглахыг хориглох, ашигласан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох;
- Гэрийн тусгаарлалтад байгаа этгээдийг зөвхөн тусгаарлалтын хугацаанд тус аппликэйшнээр дамжуулан хянах;
- “Ковид-19”-ийн тархалт зогссон гэж үзсэн тохиолдолд зорчсон мэдээллийг хадгалах процессыг зогсоох, маршрутын мэдээллээ иргэд өөрсдөө устгах боломж олгох;

- Иргэдийн зорчсон мэдээлэлд өөр зорилгоор нэвтэрсэн, мэдээллийг ашигласан, нэвтрэх эрх өгөгдөөгүй иргэний мэдээлэлд нэвтэрсэн зэрэгт хөндлөнгийн хяналт тавих тогтолцоог бүрдүүлэх, буруутай этгээдэд хариуцлага тооцох;
- Иргэдийн зорчсон мэдээлэлд нэвтрэх нь халдашгүй байх үндсэн эрхийг хязгаарлаж буй хэрэг тул дээрх өгөгдөлтэй холбоотой харилцааг Өгөгдөл хамгаалах тухай хууль шинээр батлах замаар болон Гамшгаас хамгаалах тухай болон Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиудад тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах замаар нарийвчлан зохицуулах;
- Технологи ашиглан хяналт тавих харилцааг зохицуулах журмыг баталж, нийтэд мэдээлэх, эсхүл Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу бүртгүүлэх ажиллагааг хийх шаардлагатай.

